



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2021 оны 3 сарын 04 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.13 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 15 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын дөрөвдүгээр бүлэгт дор дурдсан агуулгатай 4.2.5 дахь заалт, 4.4 дэх хэсгийг тус тус нэмсүгэй:

“4.2.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэргийн анги, салбарт алба хааж байгаа сонгогч.

4.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд өөрийн байнга оршин суугаа аймаг болон нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа энэ журмын 4.1-д заасан сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар тухайн сонгогчийн оршин байгаа газарт нь очиж авна.”

2. Мөн тогтоолын 1 дүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурлын” гэсний өмнө “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль,” гэж, 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь хэсгийн “4.2.4” гэсний дараа “, 4.2.5” гэж тус тус нэмсүгэй.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000043